



“МИАТ” ТӨХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.09.11 № 01/1536
танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичиг
хянасан тухай**

Танай компаниас зарласан “Агаарын хөлгийн иж бүрэн даатгал” МИАТ/20240103122 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Ард даатгал” ХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1-д “Олон улсын даатгалын зах зээл дээр Даатгуулагчийн агаарын хөлгийн даатгалыг тэргүүлэх Тэргүүлэгч буюу Үндсэн давхар даатгагчаар ажиллах компанийн баталгаа бүхий албан захидал, орчуулгын хамт ирүүлнэ. Тэргүүлэгч нь албан захидалдаа (а) даатгалын нийт эрсдэлийн 10% багагүй хувийн эрсдэлийг захиалан авахаа баталгаажуулсан байх; (б) ижил төстэй болон дэлхийн томоохон агаарын тээврийн компанийн агаарын хөлгийн даатгал/давхар даатгалыг тэргүүлж байсан туршлагын талаар мэдээллийг ирүүлнэ.” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.” гэж, 11.2-т “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д “...Тэргүүлэгч нь албан захидалдаа (а) даатгалын нийт эрсдэлийн 10% багагүй хувийн эрсдэлийг захиалан авахаа баталгаажуулсан байх; (б) ижил төстэй болон дэлхийн томоохон агаарын тээврийн компанийн агаарын хөлгийн даатгал/давхар даатгалыг тэргүүлж байсан туршлагын талаар мэдээллийг ирүүлнэ.” гэж заасан нь Төрийн болон орон нутгийн

0003549

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн, өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй байна.

Иймд тус тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА



Б.БИЛГҮҮН